

Гадаад худалдаа, интеграцын бодлого: Евроазийн эдийн засгийн холбоо

Дашхүүгийн Батмөнх

Докторант, шинжээч, batmunkh@iss.gov.mn

Монгол Улс, Улаанбаатар, Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн

Стратеги судалгааны хүрээлэн

Хураангуй

Олон улсын худалдаанд сүүлийн жилүүдэд геополитикийн зөрчилдөөнөөс үүдэлтэй тодорхой бус байдал үүсэж, улс орнууд хоёр талт болон хил орчмын худалдаанд түлхүү анхаарал хандуулах болов. Даяарших үйл явц хуучин том төвүүд рүү чиглэсэн бол өдгөө хил залгаа улс хоорондын болон бүс нутгийн худалдаанд анхаарал хандуулж дангаарших үйл явц илүү түгэх болов. Энэ нөхцөлд манай улс гадаад худалдаа, интеграцыг хөгжүүлэхийн тулд бүс нутгийн хамтын ажиллагаанд анхаарал хандуулж буй илрэл нь Евроазийн эдийн засгийн холбоотой чөлөөт худалдааны түр хэлэлцээр байгуулах явдал юм. Мөн Монгол Улсын Ерөнхийлөгч У.Хүрэлсүх Төв Азийн орнуудад албан ёсны айлчлал хийж, тус бүс нутгийн худалдаа, эдийн засгийн хамтын ажиллагааг өргөжүүлж, бүс нутгийн интеграцыг хөгжүүлэхэд чухал алхмуудыг хийсэн.

Иймд энэхүү судалгааны хүрээнд гадаад худалдаа, интеграцыг хөгжүүлэхэд Евроазийн эдийн засгийн холбоотой байгуулах чөлөөт худалдааны хэлэлцээрийн давуу болон сул талуудыг судалж, өөрийн улсын эрх ашиг аюулгүй байдлыг хангахад ямар асуудал байгааг авч үзлээ.

Судалгааны үр дүнгээс үзвэл Евроазийн эдийн засгийн холбоотой манай улс чөлөөт худалдааны хэлэлцээр байгуулснаар урт хугацаанд ашигтай бөгөөд богино хугацаанд дотоодын хүнсний үйлдвэрлэлд сөрөг нөлөөтэй байна.

Түлхүүр үг: Эдийн засгийн аюулгүй байдал, хэлэлцээр, экспорт, импорт, тариф

Оршил

Монгол Улсын үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалын эдийн засгийн аюулгүй байдлын 3.2.5.-д гадаад худалдаа, интеграцын бодлогыг дараах зүйлд авч үзсэн.

3.2.5.1. Цөөн зах зээл, цөөн нэр төрлийн бүтээгдэхүүний экспорт, импортоос хэт хамааралтай үндэсний эдийн засгийн эмзэг байдлыг бууруулна.

3.2.5.2. Гадаад худалдааны алдагдлыг багасгаж, тарифын болон тарифын бус арга хэрэгслийг дотоодын үйлдвэрлэлийг дэмжих зорилгоор зохистой хэрэглэнэ. Стратегийн бараа, түүхий эдээр үндэсний үйлдвэрлэлийг найдвартай хангаж, үйлдвэрлэлийн тоног төхөөрөмжийн импортын таатай нөхцөлийг бүрдүүлнэ.

3.2.5.3. *Нэг орноос худалдан авах бараа бүтээгдэхүүн нийт импортод хэт давамгайлахаас сэргийлэх бодлого баримтална. Түүхий эд бэлтгэл, бөөний болон жижиглэн худалдаанд үнийн зохиомол хэлбэлзэл, монопол, шударга бус өрсөлдөөнийг хянан зохицуулна. Дотоодын үйлдвэрлэл, зах зээлийг хамгаалах эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгоно.*

3.2.5.4. *Бүс нутгийн болон олон улсын интеграцад нэгдэх, чөлөөт худалдааны хэлэлцээр байгуулах асуудлыг эдийн засгийн аюулгүй байдал, хөгжлийн шаардлагыг харгалзан, судалгаа, тооцоонд тулгуурлан, шат дараатай, сонголттойгоор хэрэгжүүлнэ гэж заасан байдаг.*

Энэ хүрээнд Монгол Улсын төр засгаас олон арга хэмжээ авч хэрэгжүүлсний үр дүнд хоёр талт болон олон талт худалдааны хэлэлцээрийг хийж ирсэн. Үүний нэг жишээ нь Евроазийн эдийн засгийн холбоотой (ЕАЭЗХ) байгуулах чөлөөт худалдааны хэлэлцээр (ЧХХ) юм.

Үндсэн хэсэг

Евроазийн эдийн засгийн холбоо (ЕАЭЗХ) нь Орос, Беларусь, Казахстаны Ерөнхийлөгчид 2014 оны тавдугаар сарын 29-ний өдөр гэрээнд гарын үсэг зурснаар 2015 оны нэгдүгээр сарын нэгний өдрөөс эхэлж хүчин төгөлдөр болсон. Уг холбоо өөрийн зарчим, зорилготой нийцэж буй бүх улсыг гишүүн нь болоход нээлтэй бөгөөд тус холбооны улсууд хоорондоо хэлэлцсэний үндсэн дээр гишүүнээр элсүүлэхээ шийддэг байна. Өнөөгийн байдлаар дээрх гурван улсаас гадна Армен (02.01.2015), Киргиз (12.08.2015) гээд нийт таван улс нэгдсэн. Мөн Молдова (14.05.2018), Куб (11.12.2020), Узбекистан (11.12.2020) ажиглагчийн байр сууртай байна.

Олон улс болон бүс нутгийн интеграцыг хөгжүүлэх зорилготой тус байгууллагын үйл ажиллагаа сүүлийн жилүүдэд геополитикийн зөрчилдөөнөөс үүдэлтэй олон сорилттой тулгарах болов. Барууны улсуудын зүгээс ОХУ-д эдийн засгийн хориг арга хэмжээ авч хэрэгжүүлсэн нь ЕАЭЗХ-ны гишүүн улс давхар хорионд орох эрсдэлээс үүдэн худалдааны асуудал дээр ихээхэн болгоомжтой хандах болсон. Иймээс тус холбооны улсын худалдаа, эдийн засгийн үйл ажиллагаа сүүлийн жилүүдэд харьцангуй суларч ирсэн. Тус бүс нутгийн худалдаа, эдийн засгийг харьцуулж үзвэл дараах байдалтай байна.

ЕАЭЗХ-ны нийгэм-эдийн засгийн үндсэн үзүүлэлтүүд:

Хүснэгт 1. ЕАЭЗХ-ны эдийн засгийн үзүүлэлтийн харьцуулалт, 2024 он

Үзүүлэлт	Дэлхий	ЕХ	АСЕАН- 5 ¹	ЕАЭЗХ	Орос	Казахстан	Беларусь	Армен	Киргиз
Хүн ам, сая хүн	8,161.9	449.2	512.4	198.3	146.1	20.1	9.1	3.0	20.1
ДНБ, тэрбум ам.доллар	110,064.9	19,403.2	3,372.0	2,591.0	2,184.3	292.6	73.1	25.3	15.8
ДНБ-ий өсөлт, хувь	3.2	1.1	4.5	4.6	3.9	4.8	4.0	6.0	6.5
Экспорт, ДНБ эзлэх хувь, 2023 он	29.3	51.9	44.6	44.6	23.1	34.4	66.8	59.5	39.2
Ажилгүйдлийн түвшин, хувь	4.9	5.9	3.2	6.5	2.6	4.8	3.0	13.0	9.0
Инфляц, жилийн дундаж хувь	5.8	2.6	2.3	5.6	7.9	8.6	6.0	0.2	5.1
Засгийн газрын өр ДНБ-д эзлэх хувь		82.7	71.7	36.0	19.9	24.8	41.4	52.4	41.8
Төлбөрийн тэнцэл, тэрбум ам.доллар	400.0	648.3	90.1	9.5	58.0	-4.5	-1.4	-1.1	-3.4


Эх сурвалж: Дэлхийн банк, Олон улсын валютын сан, тухайн улсын статистик мэдээнд үндэслэв.

Орос-Украины дайн 2022 оноос хойш өнөөг хүртэл үргэлжилж, эдийн засгийн бүх төрлийн хоригт байгаа ОХУ-ын эдийн засгийн өсөлт 2024 онд 3.9-4 хувийн (TASS, 2024) өсөлттэй гарснаас үзвэл дайн эхэлснээс хойш сүүлийн хоёр жил дараалан өсжээ. Энэ үзүүлэлтэд хүрсэн нь ЕАЭЗХ болон Хамтын нөхөрлөлийн улсуудын хамтын ажиллагааны үр дүн гэж ОХУ-ын Ерөнхийлөгч В.В.Путин мэдэгдсэн байна. Үүнд: Беларусийн эдийн засаг 2024 онд 5.5 хувийн өсөлт үзүүлсэн бөгөөд Армен, Оросын гадаад худалдаа бараг хоёр дахин нэмэгджээ. Харин олон улсын шинжээчдийн үзэж байгаагаар 2025 онд ОХУ-ын эдийн засгийн өсөлтийн хурд саарч, 1.3 хувийн өсөлттэй байхаар төлөв гарчээ (International Monetary Fund (IMF), 2024; Placeholder1). Мөн ЕАЭЗХ-ны улсуудын ДНБ 2024 онд өмнөх жилтэй харьцуулахад 4.5 хувиар өсөж цар тахлын дараа тус холбооны эдийн засаг сэргэж

¹ АСЕАН-ны үндэслэгч таван улс Индонез, Малайз, Филиппин, Сингапур, Тайланд

эхэлсэн жилийн хэмжээнд хүрсэн. Харин ЕАЭЗХ-ны ДНБ-ий өсөлтийн хурд 2025 онд саарч, маш бага хэмжээнд өсөхөөр байна. Үүний гол шалтгаан нь ОХУ-ын эдийн засгийн өсөлт удааширч барууны орнуудын зүгээс тавьсан хориг арга хэмжээний үр дагавар нөлөөллөө үзүүлэхтэй холбож үзэж болно.


График 1. ЕАЭЗХ-ны улсуудын ДНБ-ий төлөв байдал, оны үнээр, тэрбум ам.доллар



Эх сурвалж: *World Economic outlook 2024, IMF October 2024*

Эдийн засгийн хэмжээгээр ЕАЭЗХ-нд дийлэнх хувийг эзэлж байдаг ОХУ дайны үед тус холбоог түшиглэн өөрийн зах зээлээ тэлэх боломж гэж үзэж байна.

График 2. ЕАЭЗХ-ны улсуудын ДНБ-ий эзлэх хувь



Эх сурвалж: *Дэлхийн банк статистик мэдээ*

ЕАЭЗХ-г байгуулахаас өмнө тус холбооны ДНБ-д эзлэх хэмжээгээр Орос 86.9, Казахстан 9.4, Беларусь 3.3, Армен 0.5, Киргиз 0.3 хувийг тус тус эзэлж байсан. Тус үзүүлэлт 2024 онд Орос 84.3 хувь буюу 2.2, Беларусь 2.8 хувь буюу 0.5 хувь пунктээр


тус тус буурсан бол Казахстан 11.3 хувь буюу 1.9, Армен 1 хувь буюу 0.5, Киргиз 0.6 хувь буюу 0.3 хувь пунктээр тус тус өсжээ.

Үүнээс үзэхэд ЕАЭЗХ-д Орос, Беларусийн эдийн засгийн хэмжээ буурсан нь Орос-Украины дайнтай шууд холбоотой нь илт харагдаж байна. Тус үйл явдлаас хамгийн их худалдааны ашиг олж буй улсаар Казахстан тэргүүлжээ. Тухайлбал: Казахстаны ДНБ өсөлт дунджаар 17 хувьд хүрч цааш улам эрчимтэйгээр өсөх төлөвтэй аж. Харин Киргиз эдийн засгаараа хамгийн сул улсын тоонд орж байна. Шалтгаан нь зах зээлд голчлон уул уурхайн түүхий эдийг экспортолж, импортоор нефтийн бүтээгдэхүүн авдаг явдал юм. Киргиз нь ЕАЭЗХ-д элсэнэнээс хойш гадаад худалдаа нь эрчимжих төлөвтэй байсан хэдий ч цар тахал, Орос-Украины дайн зэрэг олон талт хямралт үйл явдлууд болсны улмаас хүссэн хэмжээндээ хүрч чадахгүй байна. Үүнээс дүгнэвэл манай улстай ижил нөхцөлтэй орны хувьд өөрийн зах зээлээ тэлэх боломж өнөөгийн байдлаар бага байна.

ЕАЭЗХ-ны дотоод худалдаа

Орос-Украины дайн эхэлснээс хойш ЕАЭЗХ-ны дотоод худалдаа буурч, Орос болон Беларусьд хамгийн ихээр нөлөөлжээ.

График 3. ЕАЭЗХ улсын хоорондох худалдааны эргэлт, мянган ам.доллар



Эх сурвалж: ITC statistics

Энэ хямралаас өмнө ОХУ гол төлөв ЕАЭЗХ-ноос уул уурхайн болон ХАА-н гаралтай бүтээгдэхүүнийг импортолж байсан бол өнөөгийн байдлаар гол төлөв цахилгаан бараа, тээврийн хэрэгсэл, машин механизм импортоор авах болжээ. Харин экспортын барааны нэр төрөл бараг өөрчлөгдөөгүй бөгөөд түүний хэмжээ огцом буурчээ. Үүнээс үзвэл тус улсын хувьд ЕАЭЗХ-той хийж буй бараа эргэлт нь өнөөгийн нөхцөл байдалтайгаа уялдуулан нэн хэрэгцээтэй бүтээгдэхүүнийг авч байгаагаараа онцлогтой байна.

Казахстаны хувьд ЕАЭЗХ-той хийсэн экспорт цар тахлаас хойш эрчимтэй өсжээ. Тухайлбал: Бусад улстай харьцуулахад 2021-2023 онд дунджаар 24.6 хувиар огцом нэмэгдэж, гол төлөв уран, төмрийн хүдэр зэрэг уул уурхайн бүтээгдэхүүнийг гаргажээ. Харин Орос-Украины дайн эхэлснээс хойш импорт дунджаар 5.7 хувиар буурсан үзүүлэлттэй байна. Казахстан ЕАЭЗХ-ноос гол төлөв нефть, тээврийн хэрэгсэл импортоор авч байсан. Гэвч сүүлийн жилүүдэд нефтиэс гадна ган хоолой их хэмжээгээр импортлох болсон нь газрын тосны бүтээгдэхүүнийг гадаад зах зээлд нийлүүлэх шугамыг нэмэгдүүлсэнтэй холбоотой аж.

ЕАЭЗХ-ны улсын худалдааны тэнцлийг авч үзвэл Орос болон Беларусь л худалдааны тэнцэл алдагдалгүй бөгөөд бусад нь бүгд алдагдалтай байна.

ЕАЭЗХ-ны гадаад худалдаа

ЕАЭЗХ-ны улсуудын гадаад худалдаа сүүлийн хоёр жил дараалан нэмэгджээ. ОХУ-ын Эдийн засгийн хөгжлийн яамны мэдээлснээр 2024 оны эхний арван сард ЕАЭЗХ-ны худалдаа 9.8 хувиар өсөж, 78.6 тэрбум ам.долларт хүрч, 2025 онд 2.9 хувийн өсөлттэй байх төлөвийг гаргажээ. Харин ОХУ-ын олон улстай хийсэн гадаад худалдаа 2024 оны эхний арван сард 584 тэрбум ам.долларт хүрсэн нь өмнөх оны мөн үеэс 1.5 хувиар буурчээ. Үүнд: экспорт нэг орчим хувь өсөж, 354.4 тэрбум ам.долларт хүрсэн бол импорт 2.7 хувиар буурч 229.8 тэрбум ам.доллар болжээ (Ministry of Economic Development of the Russian Federation, 2025.03). Импорт буурах гол шалтгаан нь хэрэглээ өмнөх жилүүдээс танагдаж, төлбөрийн шилжүүлэг хийхэд хүндрэлтэй нөхцөл бий болсонтой холбоотой гэж үзжээ.

Эдийн засгийн хөгжлийн яамны орлогч сайд Владимир Ильичев ОХУ-ын экспортын чиг баримжааг өөрчлөх нэгдүгээр үе шат² дууссан тухай мэдэгдсэн юм. Тэрээр “Хоёр дахь үе шат бол шинэ зах зээлийг нээх буюу АСЕАН-ны орнуудад чиглэх явдал” гэж тэмдэглэжээ. Оросын гадаад худалдааны гол түнш таван улсыг өнөөгийн байдлаар Хятад тэргүүлж байгаа бол Энэтхэг, Турк болон ЕАЭЗХ-ны гишүүн Беларусь, Казахстан удаалж байна.

ЕАЭЗХ-той хийх чөлөөт худалдааны хэлэлцээр

Эдийн засгийн хориг арга хэмжээнд орсон амаргүй нөхцөлд гадаад худалдааг өргөжүүлэх боломжийн нэг нь чөлөөт худалдааны хэлэлцээр (ЧХХ) гэж үзэж байна (TASS, 2025). ЕАЭЗХ-ноос сүүлийн жилүүдэд хэд хэдэн улс оронтой ЧХХ байгуулахаар төлөвлөөд байна. Тухайлбал:

- БНХАУ-тай байгуулах чөлөөт худалдааны хэлэлцээрт гишүүн орнуудын санал нэгдэхгүй байна. Учир нь тус хэлэлцээрээс гарах үр нөлөөг тооцоолоход хугацаа хэрэгтэй гэж үзжээ. Оросын хувьд Хятадтай байгуулах ЧХХ-ийн тал дээр болгоомжтой хандаж байгаа юм. Хоёр улсын худалдааны татвар 4.5 хувь буюу хамгийн бага байхад заавал ЧХХ хийх

² Барууны өндөр хөгжилтэй улсаас хөгжиж буй зах зээлд шилжих үйл явц.

шаардлага байхгүй. Харин хоёр улсын худалдааг нэмэгдүүлэхэд дэд бүтэц, логистик, төлбөрийн шилжүүлгийг улам боловсронгуй болгох нь чухал ач холбогдолтой бөгөөд эрсдэл бага гэж тооцоолжээ.

- БНЭУ-тай байгуулах ЧХХ-ийн асуудал урт хугацааны туршид яригдаж байна. Өнөөгийн байдлаар тус асуудлын хүрээнд ЕАЭЗХ-ны зүгээс бүх шийдвэрийг гаргасан. Одоогоор Энэтхэгийн зүгээс зөвхөн албан ёсны хариуг хүлээж байгаа ч энэ жилдээ ЧХХ-ийг хийх төлөвтэй.
- АНЭУ-тай ЧХХ-ийг хийх ажил үндсэндээ дуусах шатандаа байна. Үүнээс гадна ЕАЭЗХ-ны улс хооронд тохиролцсон ёсоор үйлчилгээний салбарт тус тусдаа ЧХХ байгуулах эрхийн дагуу ОХУ энэ жил АНЭУ-тай хамтран ажиллахаар төлөвлөөд байна.
- БНИндУ-тай байгуулж буй ЧХХ-ийн ажил дуусах шатандаа байна. Энэ жил багтаад хэлэлцээрт гарын үсэг зурах төлөвтэй байна.
- БНТунУ-тай ЧХХ байгуулах ажил судалгааны түвшинд байна. Хэлэлцээр байгуулах асуудлын талаар албан ёсны яриа, хэлэлцээ энэ жил эхлэх төлөвтэй.
- АБНЕгиУ-тай байгуулж буй ЧХХ-ийн үйл ажиллагаа зогсонги байна. Хоёр тал аж үйлдвэрийн бүтээгдэхүүний худалдаан дээр тохиролцсон хэдий ч Египетийн талаас ХАА-н салбарын бүтээгдэхүүний асуудал дээр тохиролцоонд хүрч чадаагүй.
- АСЕАН буюу Ази Номхон далайн улс орнуудтай ЧХХ-ийг байгуулахаас илүүтэй гишүүн улстай нь хамтран ажиллахыг чухалчилсан. Тухайлбал: Вьетнамтай байгуулсан ЧХХ нь АСЕАН-ы бусад гишүүн орны зах зээлтэй шууд холбогдох гүүр болж, стратегийн давуу талыг бий болгосон.
- ТХУ (Тайланд)-ын хувьд ЧХХ байгуулах талаар санал тавьсан. Энэ хэлэлцээр Индонезтэй байгуулсан ЧХХ хэр зэрэг үр дүнтэй байхаас шалтгаална гэж үзэж байна.
- Монгол Улсын хувьд ЧХХ-ийг байгуулах шатандаа явж байна. Өнөөгийн байдлаар зарим асуудлыг эцэслэн тохиролцоогүй байгаа тул түр хойшилсон хэвээр байна.

ЕАЭЗХ-той хийх худалдааны давуу, сул тал

Давуу тал:

- Цэвэр органик бүтээгдэхүүн;
- Хуучин зах зээл (олонд танигдсан);
- Бүтээгдэхүүний өвөрмөц шинж.

Сул тал:

- Цөөн нэр төрлийн бүтээгдэхүүн;

- Гол төлөв түүхий эд;
- Тоо, хэмжээ бага буюу масс үйлдвэрлэл;
- Бэлтгэн нийлүүлэлтийн сүлжээ сул;
- Бүтээгдэхүүний чанар, стандарт бусад улстай харьцуулахад сул (техник, технологи хуучирснаас зардал их, бүтээгдэхүүний үнэ өндөр);
- Тээвэр логистик сул хөгжсөн;
- Тээврийн зардал өндөр;
- Сав баглаа боодол;
- Хүнд суртал.

Боломж:

- Зах зээлээ тэлэх;
- Гадаад худалдаа, интеграцыг өргөжүүлэх;
- Эдийн засгийг төрөлжүүлэх.

Эрсдэл:

- Дотоод зах зээлээ алдах;
- Чөлөөт өрсөлдөөнийг хаах.

Монгол Улс ЕАЭЗХ-той хийж буй худалдаа


Импорт: Монгол Улс ЕАЭЗХ-той 2024 онд гурван тэрбум ам.долларын худалдаа хийсэн нь өмнөх оноос 14.9 хувиар өсжээ. Тус холбооны улстай хийсэн худалдаанд хамгийн их хувийг Орос 2.9 тэрбум, Казахстан 54 сая, Беларусь 24.6 сая, Киргиз 4.2 сая, Армен 723 мянган ам.долларын худалдааг тус тус хийжээ. Харин ЕАЭЗХ-оос импортоор 2,899.0 сая ам.долларын бараа авсан нь нийт импортын 25 хувь болсон бол экспорт 110 сая ам.долларт хүрсэн нь нийт худалдааны 0.7 хувь болж байна.

Манай улс 2024 онд ЕАЭЗХ-ноос нефтийн бүтээгдэхүүнийг хамгийн их хэмжээтэй буюу 2.89 тэрбум, азотын бордоог 67.8 сая, цахилгаан эрчим хүчийг 67.4 сая ам.доллараар тус тус худалдан авчээ. Өөрөөр хэлбэл: Дээрх бүтээгдэхүүнийг зөвхөн ОХУ-аас авчээ. Харин дараах улс оронтой импортын худалдаа хийжээ. Тухайлбал:

- Казахстанас импортоор 47.3 сая ам.долларын бараа бүтээгдэхүүнийг худалдан авсан. Үүнээс сигар, янжуур хамгийн ихээр буюу 25.3 сая, нефтийн бүтээгдэхүүн 2.4 сая, замын хөдөлгөөнийг зохицуулах, аюулгүй байдлыг хангах бүх төрлийн цахилгаан дохиоллын төхөөрөмжийг 2.37 сая ам.доллараар тус тус худалдан авсан байна.
- Беларусиаас импортоор 24.6 сая ам.долларын бүтээгдэхүүн худалдан авснаас хамгийн их нь элсэн чихэр 5.8 сая, өтгөрүүлсэн болон хуурай сүү, цөцгийг 3.5 сая ам.доллараар тус тус авчээ.

- Киргизээс 1.6 сая ам.долларын бүтээгдэхүүнийг импортолсон. Үүнд шоколад ба какао агуулсан бусад хүнс 483.6 мянга, талх, амтлаг гурилан бүтээгдэхүүн 410.2 мянган ам.долларын худалдаа хийжээ.
- Арменаас импортоор 654.8 мянган ам.долларын бүтээгдэхүүнийг оруулжээ. Үүнээс хамгийн их нь сигар, янжуур 173.9 мянга, оёмол пальто, цув, дулаан хүрэм, эрэгтэй нөмрөгийг 114.8 мянган ам.доллараар арилжаа хийсэн байна.

**График 4. Монгол Улс ЕАЭЗХ-той хийсэн худалдааны эргэлт,
мянган ам.доллар**



Эх сурвалж: ITC statistic


Экспорт: Монгол Улс 2024 онд ЕАЭЗХ-д 110.1 сая ам.долларын бараа, бүтээгдэхүүнийг экспортолсон. Үүнээс Орост хээрийн болон хайлуур жонш, дугуй, төрөл бүрийн бараа 95.6 сая ам.доллар болсон бол Казахстанд 3.5 сая ам.долларын адууны мах, 3.4 сая ам.долларын автомашиныг арилжжээ.

Монгол Улс ЕАЭЗХ-той хийсэн худалдааны алдагдал 2.8 тэрбум ам.долларт хүрчээ. Энэ нь ЕАЭЗХ-ны улсаас ОХУ-тай хамгийн их буюу 2.7 тэрбум ам.долларт хүрсэн үзүүлэлт нь нийт алдагдлын 98 хувийг эзэлж байгаа нь эдийн засгийн аюулгүй байдлын эрсдэлийг нэмэгдүүлж байна. Киргизээс бусад бүх улсаас худалдааны алдагдал хүлээжээ. Энэ алдагдал цаашид ч мөн өсөх төлөвтэй. Иймээс тус алдагдлыг багасгахын тулд экспортыг нэмэгдүүлэх хэрэгтэй байна. Улмаар ЕАЭЗХ-ны гишүүн орнуудын хооронд худалдааны түр хэлэлцээр байгуулснаар энэ алдагдлыг багасгах боломжтой гэж үзэж байна. Хэлэлцээр байгуулснаар хоёр талаас 375 нэр төрлийн бүтээгдэхүүнд тарифын хөнгөлөлт үзүүлэх тухай яригдаж байгаа юм. Үүнд гол төлөв ХАА-н бүтээгдэхүүнүүд зонхилж байна.

Статистик мэдээнээс үзэхэд ОХУ-ын хувьд 2023 онд 10 тэрбум ам.долларын ХАА-н гаралтай хүнсний бүтээгдэхүүнийг олон улсын зах зээлээс импортолжээ.

Үүнээс үзэхэд манай улс ЕАЭЗХ-ны зах зээлд ХАА-н гаралтай бүтээгдэхүүнийг экспортлох бүрэн боломжтой байна.

**График 5. Монгол Улс ЕАЭЗХ-той хийсэн худалдааны тэнцэл,
мянган ам.доллар**



Эх сурвалж: ITC statistic

ЕАЭЗХ-той хийж буй худалдааны түр хэлэлцээрийг байгуулснаар газар тариалангийн салбарт өрсөлдөөнийг бий болгох талтай. Энэ нь манай улс сүүлийн жилүүдэд тус салбарт онцгой анхаарч ирсэн “Атарын” I-IV аяны үр дүнг сулруулах хандлагатай байгааг анхаарах нь зүйтэй. Мөн хүнсний зах зээл дээр өрсөлдөөн бий болж гурилын үнэ буурах эерэг талтай боловч дотоодын үйлдвэрлэгчид өрсөлдөөнд бэлэн биш байгаа тул тус салбарыг бүхэлд нь доройтуулах эрсдэлийг бий болгохоор байна.

Дүгнэлт

Олон улсад болж буй их гүрнүүдийн геополитикийн сөргөлдөөн, цар тахлаас үүдсэн ЕАЭЗХ-ны гадаад худалдааны бууралтад голлон нөлөөлсөн нь Орос, Беларусь бол харин бусад гишүүн орны худалдаа өсжээ. Үүнээс үзэхэд тус холбооны нэгдсэн зах зээл дайн эхэлснээс хойш ихээхэн хумигдсан байна.

Мөн ЕАЭЗХ-ны дотоод худалдаа буурч, гадаад худалдаанд бүтцийн өөрчлөлт бий болжээ. Тухайлбал: ЕАЭЗХ-д эдийн засаг, зах зээлээр үлэмж жин дардаг ОХУ-ын хувьд дайн эхэлснээс хойш импорт нь голчлон утас, цахилгаан бараа зэрэг хэрэглээний бүтээгдэхүүнээр хязгаарлагдаж, харин экспорт нь нефть, үр тарианд төвлөрөх болжээ. Энэ нь ОХУ-ын хувьд ЕАЭЗХ-ны тусламжтайгаар барууны орнуудын зүгээс тавьсан хоригийг сулруулах нэг механизм нь болж байна.

ЕАЭЗХ-ноос баримталж байгаа нэг чухал зүйл бол олон улстай ЧХХ-ийг байгуулахыг зорьж байгаа явдал юм. Улмаар Иран, Вьетнамтай хэлэлцээр байгуулж,

хэд хэдэн оронтой энэ жил гэрээ байгуулахаар төлөвлөжээ. Монгол Улсын хувьд ЧХХ байгуулах үйл ажиллагаа түр саатаж, зогсонги байдалд байна. Энэ хэлэлцээрийг ОХУ-ын зүгээс үзэглэх сонирхол их байдаг. Учир нь ОХУ-ын зүгээс ЕАЭЗХ-г түшиглэж аль болох олон улстай ЧХХ байгуулах сонирхол их. Хэрвээ ОХУ барууны орнуудтай тохиролцоонд хүрч дайн дуусвал Оросын тал ийм боломжийг дахин олгохгүй байх магадлал өндөр юм.

Монгол Улс ОХУ-тай худалдааны түр хэлэлцээрийг байгуулснаар ХАА-н бүтээгдэхүүнийг ЕАЭЗХ-ны улсуудын зах зээлд гаргах боломжийг нээх болно. Энэ нь тус холбоотой хийж буй худалдааны 2.8 тэрбум ам.долларын алдагдлыг багасгах боломжийг бүрдүүлэх юм. Харин газар тариалангийн салбар энэ өрсөлдөөнд бэлэн биш байгаа тул тус салбарын 1500 ААН, 16189 өрхөд төр засгаас онцгой анхаарч үүнд чиглэсэн тодорхой бодлогыг боловсруулах зайлшгүй шаардлагатай байна.

Эх сурвалжийн жагсаалт

International Monetary Fund (IMF). (2024). *World economic outlook: Navigating global divergences, October 2024* [Дэлхийн эдийн засгийн төлөв: ...]. Washington, DC: International Monetary Fund. <https://www.imf.org/en/Publications/WEO/Issues/2024/10/22/world-economic-outlook-october-2024>

Ministry of Economic Development of the Russian Federation. (2025.03). *ОХУ-ын гадаад худалдааны жилийн мэдээний талаархи мэдэгдэл* [Press release on the annual foreign trade report of the Russian Federation]. Moscow: Ministry of Economic Development of the Russian Federation.

TASS. (2024 оны December 26). *Путин: экономика РФ выросла почти на 4 % за 2024 год* [Путин: Оросын эдийн засаг 2024 онд бараг 4 %-иар өссөн]. <https://tass.ru/ekonomika/22782139>

TASS. (2025 оны 06). *Замглавы Минэкономразвития: переориентация российского экспорта пока прошла только первый этап* [Өрсөлдөх экспортын чиг баримжаа хийхэд эхний үе шат л дууссан]. <https://nangs.org/news/economics/zamglavy-minekonomrazvitiya-pereorientatsiya-rossijskogo-eksporta-poka-proshla-tolko-pervyj-etap>

Foreign Trade and Integration Policy: Eurasian Economic Union

Batmunkh Dashkhuu

Ph.D., candidate, Expert, batmunkh@iss.gov.mn

The Institute for Strategic Studies,
National Security Council, Ulaanbaatar, Mongolia

Abstract

In recent years, international trade has been characterized by uncertainty due to geopolitical conflicts, and countries have increasingly focused on bilateral and cross-border trade. While the globalization process was directed towards the old major centers, the process of fragmentation of international trade has become more concentrated, focusing on cross-border and regional trade. In this context, the establishment of an interim free trade agreement with the Eurasian Economic Union is a manifestation of our country's focus on regional cooperation to develop foreign trade and integration. In addition, Mongolian President Ukhnaagiin Khurelsukh, made an official visit to Central Asia countries, expanding trade and economic cooperation in the region and taking important steps to develop regional integration.

Therefore, this research work is aimed at studying the advantage and disadvantage of free trade experiments related to the economic activities of Eurasia in the development of foreign trade and integration, and identifying the problems in ensuring the security of the interests of our country.

According to the results of the study, our country's signing the free trade agreement with the Eurasian Economic Union will be beneficial in the long-term but will be a negative impact on domestic food production in the short term.

Keywords: Economic security, Negotiation, Export, Import, Tariff

Received: September 10, 2025 | Accepted: September 17, 2025 | Published online: October 13, 2025



© The Author(s) 2025

<http://creativecommons.org/licenses/by/4.0/>.